

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 09 дүгээр сарын 01

Тендер шалгаруулалтын нэр: **Хүнд даацын автомашин** нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: **ХХ-2017/03-29**

Эрдэнэт үйлдвэр ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Хүнд даацын автомашин** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Худалдаа хөгжлийн банкны Орхон аймгийн салбар дахь **Эрдэнэт үйлдвэр ХХК**-ийн 407 016 667 тоот дансанд төлсөн байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 3 жил /2014 он, 2015 он, 2016 он/**

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 3 жил (2014 он, 2015 он, 2016 он)-ийн аль нэг жилд гүйцэтгэсэн нийт борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.**

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн **1** хувиас багагүй төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 11 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны II байр, 352 тоот өрөө,

Утас: 75759999-73790

Факс: 70353002

Вэб сайт: www.erdenetmc.mn

E-mail: b.oyunchimeg@erdenetmc.mn